



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/345

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Сумын төвийн хатуу хучилттай авто зам барих (Рашаант сум) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Энх алтаргана” ХХК-тай 499 915 004 (дөрвөн зуун ерэн есөн сая есөн зуун арван таван мянга дөрөв) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.


3.Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Рашаант сумын Засаг дарга (Б.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Энх алтаргана” ХХК-ийн захирал (А.Энхжаргал)-д даалгасугай.

5.Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

6.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 15-ны/ний өдрийн А/ЗЧС дугаар
захирамжийн хавсралт

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	8,761,469	Ү.Бямбасүрэн
2	Зөвлөх үйлчилгээний зардал	0	Ү.Бямбасүрэн
3	Захиалагчийн хяналтын зардал	7,520,463	Ү.Бямбасүрэн
4	Норм, нормативын сан	1,752,294	Ү.Бямбасүрэн
5	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
6	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь	Д.Батцогт Ү.Бямбасүрэн
7	Ажил гүйцэтгэх хугацаа	60 хоног	Ү.Бямбасүрэн